ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Утас/Факс: (976) 7054 3005,
И-мэйл: zdtg.gsa@gmail.com, Вэбсайт: www.govisumber.gov.mn

2023.10.09 № Б/484

танай ______ -ны № ______ -т

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАРТ

Говьсүмбэр аймгийн хэмжээнд 2023 оны гуравдугаар улиралд иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээг хүргүүлэв.

Хавсралт 4 хуудастай.

ОРЛОГЧ ДАРГА Б.НАРАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 494 албан тоотын 1 дүгээр хавсралт

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2023 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН

Хүснэгт-1

| № | Байгууллагын нэр | Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн тоо | Шийдвэрлэлт | | | | Шийдвэрлэлт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Шийдвэрлэж хариу өгсөн | Бусад байгууллагад шилжүүлж шийдвэрлэсэн | Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн | Хугацаа болоогүй | |
| 1 | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | 7 | 7 | - | - | - | 100% |
| 2 | Аймгийн Засаг даргад | 55 | 50 | 1 | - | 4 | 100% |
| 3 | Аймгийн Засаг даргын дэргэдэх харъяа хэлтэс, агентлагт | 250 | 215 | - | - | 35 | 100% |
| 4 | Сумд /Сүмбэр, Шивээговь, Баянтал/ | 212 | 206 | - | - | 6 | 100% |
| Дүн | | 524 | 478 | 1 | - | 45 | 100% |

## 2023 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН БАЙДЛААР ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ /ХЭЛБЭРЭЭР/

Хүснэгт 2

| № | Байгууллагын нэр | Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн тоо | Үүнээс: | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Бичгээр | Цахимаар | Утсаар | Биечлэн уулзсан | Бусад хэлбэрээр |
| 1 | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлад | 7 | 7 | - | - | - | |
| 2 | Аймгийн Засаг даргад | 55 | 53 | | 2 | - | |
| 3 | Аймгийн Засаг даргын дэргэдэх харъяа хэлтэс, агентлагт | 250 | 215 | 30 | 5 | - | |
| 4 | Сумд /Сүмбэр, Шивээговь, Баянтал/ | 212 | 212 | - | - | - | |
| Дүн | | 524 | 487 | 30 | 7 | - | |

# 2023 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН БАЙДЛААР ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТИЙН АГУУЛГА

Хүснэгт-3

<table>
<tr><td>1</td><td>Говьсүмбэр аймаг</td><td>Нийт 524 өргөдлөөс 1. Хүсэлт-524(100%)<br>2. Гомдол-0<br>3. Санал-0<br>4. Талархал-0<br>Хамгийн олон иргэн хандсан асуудлууд:<br>1. Газрын асуудлаар 331<br>2. Тусламж, дэмжлэг хүссэн өргөдөл-60<br>3. Хүлэмж хүссэн өргөдөл-26<br>4. Цаг агаарын тодорхойлолт лавлагаа-25<br>5. Тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах тухай хүсэлт-6<br>6. Худаг гаргах зөвшөөрөл хүссэн- 4<br>7. Байгаль орчны үнэлгээ хийлгэх хүсэлт-2<br>8. Бусад асуудлаар-70<br>Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, аж ахуйн нэгж, иргэдээс өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг бичгээр, амаар, цахим сүлжээ <u>govisumber.gov.mn</u>, санал хүсэлтийн хайрцаг, 70543434 дугаартай утсаар хүлээн авч, холбогдох албан тушаалтанд танилцуулж, бүртгэл хяналтын картаар шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин, өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, холбогдох эзэнд нь хариуг өгч ажиллаж байна.</td></tr>
</table>

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугээр
сарын 09-ны өдрийн 984 албан тоотын
2 дугаар хавсралт

## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2023 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагууд нь байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг бичгээр, амаар, цахим сүлжээ, санал хүсэлтийн хайрцаг, 70543434 дугаарын нээлттэй утсаар хүлээн авч, холбогдох албан тушаалтанд танилцуулж, бүртгэл хяналтын картаар шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин, ажиллаж байна.

**Аймгийн Засаг даргад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтэд тусгагдсан асуудлыг ангилан авч үзвэл:**

- Дэмжлэг хүссэн - 21
- Газрын асуудлаар – 15
- Хүсэлт – 8
- Гэр хүсэх тухай- 5
- Байрны түрээсийн дэмжлэг хүсэх тухай - 4
- Зөвшөөрөл хүссэн тухай 2

Нийт 55 өргөдөл ирснээс гэр хүссэн 5 өргөдөл ирснийг судлан, гэр олгох боломжгүй тухай мэдэгдсэн.Тусламж хүссэн 6 иргэний өргөдлийг шийдвэрлэн 1.3 сая төгрөгийн тусламж үзүүлсэн. Мөн дэмжлэг хүссэн 9 иргэний өргөдлийг шийдвэрлэж, нийт 4.6 сая төгрөгийн дэмжлэгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс олгосон. Газрын асуудлаар ирүүлсэн 15 өргөдлөөс 14 өргөдлийг хууль журмын дагуу шийдвэрлэж, 1 өргөдөл хугацаа болоогүй байна. Аймгийн Засаг даргад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн ажиллаж байна. 2023 оны 3 дугаар улирлын байдлаар хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт байхгүй, хугацаа болоогүй шийдвэрлэх шатанд 6 өргөдөл байна. Сумдын Засаг дарга нарт нийт 212 өргөдөл ирсэн бөгөөд төрлөөр нь ангилбал:

- Газрын асуудлаар-136 (16 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна)
- Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох тухай 28 өргөдлийг судлан үзэж сумын Засаг даргын захирамжаар асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон.
- Дэмжлэг хүссэн 15 иргэний өргөдлийг шийдвэрлэн нийт 3080500 төгрөгийн дэмжлэгийг олгосон.
- Буцалтгүй тусламж хүссэн 15 өргөдлийг судалж үзээд сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 14.18 сая төгрөгийн тусламж үзүүлсэн.
- Тусгай зөвшөөрөл шинээр авах 6 хүсэлтийг судлан хууль, журмын дагуу шаардлага хангасан тул тусгай зөвшөөрлийг олгосон. 1 иргэний өргөдөл материал дутуу учраас буцаагдсан байна
- Худаг, усны асуудлаар 4 өргөдөл ирснийг 1 иргэний хүсэлтийг буцаасан байна.
- Хүүхэд үрчлэх 2 хүсэлт ирснийг хамтарсан багаар шийдвэрлэсэн.
- Бусад асуудлаар 6 өргөдөл ирснийг шийдвэрлэсэн.

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**